

“БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН ҮЕ ШАТ, ТҮҮНИЙ БҮРДЭЛ” БАРИЛГЫН ДҮРЭМ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Барилгын тухай” Монгол Улсын хууль 2016 онд шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор дагаж гарах дүрэм журмуудыг шинэчлэн баталсны нэг нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдөр №108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм” юм. Энэхүү дүрмийг барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангуулах, хуульд заасан үе шатны дагуу зураг төслийг боловсруулах, хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангах, зөвшилцөх болон зураг төсөлд магадлал хийх, баталгаажуулах, хадгалахтай холбоотой үйл ажиллагаанд мөрдөхөөр зохицуулсан.

Барилгын тухай хууль-ийн 23.3.1-д: Барилга байгууламжийн төвөгшлөөрөө онцгой төвөгшилтэй ангилалд хамаарах болон цогцолбороор баригдах барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлыг “техникийн зураг”, “ажлын зураг” гэсэн хоёр үе шаттайгаар, бусад барилга байгууламжийг “ажлын зураг” гэсэн нэг үе шаттайгаар боловсруулахаар зааж өгсөн.

Барилгын салбарт оруулах хөрөнгө оруулалт нэмэгдэхийн хирээр гадны байгууллагаар гүйцэтгүүлсэн барилга байгууламжийн зураг төслөөр барилга угсралтын ажил гүйцэтгэх нь түгээмэл болж байна. Иймд “Барилгын тухай” хуулийн 23.3.1 болон доор дурдагдсан заалтуудын мөрдөгдөх нөхцлийг хангах боломжийг бүрдүүлэх нь төрийн захиргааны байгууллагын эрхлэх хүрээний ажил тул “Барилга байгууламжийн зураг төслийн үе шат, түүний бүрдэл” болон “Барилгын зургийн даалгаврын өгөгдлийн аргачлал” боловсруулах зөвлөмжийн чанартай баримт бичгийг зураг төсөл зохиогч, барилгын үйл ажиллагаа эрхлэгч нарт зориулан нэгдсэн нэг ойлголттой болох үүднээс боловсруулалтыг хийж байгаа болно.

“Барилгын тухай хууль”-ийн 4.1.30.“зураг төсөл” гэж барилга байгууламжийг төлөвлөх, барилгын ажил гүйцэтгэхэд шаардагдах загвар зураг, эх загвар зураг /эскиз/, техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл, инженер хайгуулын судалгаа, инженер геологи, геодезийн зураглал, инженерийн тооцоо, өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг;

4.1.16.“барилга байгууламжийн зураг төслийн магадлал” гэж барилга байгууламжийн зураг төсөл, технологи, өргөх байгууламжийн сонголт, хот болон архитектур төлөвлөлт, үндсэн бүтээцийн бат бэхийн шийдэл барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлага, хэрэглэгчийн аюулгүй байдлыг хангасан эсэхэд дүгнэлт гаргах хараат бус, бие даасан мэргэжлийн үйл ажиллагааг;

4.1.26 “гүйцэтгэлийн зураг” гэж батлагдсан зураг төслийг зохиогчийн зөвшөөрлөөр өөрчилж, эрх бүхий этгээдийн баталгаажуулсан барилгын ажлын зураг төслийг;

4.1.27 “загвар зураг” гэж барилга байгууламжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, орчны тойм, эзлэхүүн төлөвлөлт, барилгын нүүр тал /фасад/, өнгөний шийдэл, төлөвлөлтийг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.43.“эх загвар зураг /эскиз/” гэж инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулсан барилга байгууламжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, тохижилт,

гудамжны дэлгээсүүд, орчны барилгуудтай уялдсан байдал, эзлэхүүн төлөвлөлт, бүтээц, инженерийн хангамжийн ерөнхий шийдэл, эрүүл ахуй, галын аюулгүй байдал, нарны тусгал, барилгын давхрын байгуулалт, огтлол, нүүр тал /фасад/, архитектур, өнгөний шийдэл, үзүүлэлтийг тодорхойлсон баримт бичгийг.

12.1.7.барилгын ажилд аюулгүй ажиллагааг хангах хөдөлмөр зохион байгуулалтын зураг боловсруулсан байх;

16.3.Барилга байгууламжийн угсралт, буулгалтын ажлыг гүйцэтгэхдээ барилгын ажлын талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөл боловсруулна.

20.10.Энэ хуулийн 20.2-т заасан барилга байгууламжийн зураг төслийг давтан хэрэглэхэд барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авахгүй.

22.1.5. Техникийн нөхцөл олгох хүсэлтэд барилга архитектурын загвар зургийг хавсаргана;

22.4.Хүсэлт гаргасан этгээд инженерийн хангамжийн хэрэгцээг өөрийн эх үүсвэрээр хангах зураг төсөл боловсруулан баталгаажуулсан тохиолдолд барилгын ажлын зөвшөөрөл олгож болно.

23.3.Энэ хуулийн 23.2-т заасан иж бүрэн ажлын зураг төслийг дараахь үе шатаар боловсруулна.

25.2.1.газар хөдлөлтийн долоо ба түүнээс дээш баллын бүсэд баригдах энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, инженерийн тооцоо, ертгийн төсөвт;

25.2.3.барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд;

25.2.4. Магадлалын инженер-геологийн дүгнэлт, геодезийн зураглалд хийнэ;

30.1.Барилгын ажлын зөвшөөрлийг барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд заасан хугацаагаар олгоно. Хугацааг барилгын ажил эхлүүлэхээр заасан өдрөөс эхлэн тооцно.

40.1.11.барилга байгууламжид хэрэглэгдсэн материал, тоног төхөөрөмж, зураг төсөлд заасан техникийн үзүүлэлтийг хангаж байгааг нотлох, шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулан баталгаажуулах;

40.1.17.барилгын ажлын явцад зураг төсөл өөрчлөгдсөн бол гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулж баталгаажуулах;

“БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, МАГАДЛАЛ ХИЙХ ДҮРЭМ”

6.12.5. барилгын ажлын талбай, үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагааны нөхцөл шаардлагыг тусгасан эсэх;

6.12.6. инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаарх дүгнэлттэй эсэх гэх мэт заалтуудаас гадна хавсралтад

“Барилга байгууламжийн зураг төслийн үе шат,
түүний бүрдэл” барилгын дүрэм боловсруулах
ажлын техникийн даалгавар

дурдагдсан стандарт баримт бичгүүдийн үг хэллэг, утга найруулга, бичиглэлийн зөрүүтэй байдлыг арилгахад дөхөм болно.

№	Нэр томъёо, тодорхойлолт	Нэр томъёо дурдагдсан хууль эрх зүйн болон норм, нормативын баримт бичиг	
		Барилгын тухай хууль	Барилгын зураг төслийн тогтолцоо. Ерөнхий журам MNS3757-1:2013
1	Барилга	4.1.1.“барилга байгууламж” гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг;	Газар доорх болон (эсвэл) газар дээрх хэсгээс бүрдсэн, хүн амьдарч, үйл ажиллагаа явуулах, үйлдвэрлэл эрхлэх, бүтээгдэхүүн хадгалах буюу мал амьтан тэжээхэл зориулагдсан, инженер-техникийн хангамжийн системээр тоноглогдсон өрөө тасалгаа бүхий барилга угсралтын ажлын үр дүн.
2	Байгууламж		Төрөл бүрийн функцийг гүйцэтгэх зориулалттай, хүн амьдарч суух, үйл ажиллагаа явуулах, үйлдвэрлэл эрхлэх, бүтээгдэхүүн хадгалах буюу мал амьтан тэжээхэд зориулагдсан, инженер техникийн хангамжийн системээр тоноглогдсон өрөө тасалгаагүй барилга угсралтын ажлын үр дүн.
3	Зураг төсөл	4.1.30 барилга байгууламжийг төлөвлөх, барилгын ажил гүйцэтгэхэд шаардагдах загвар зураг, эх загвар зураг /эскиз/, техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл, инженер хайгуулын судалгаа, инженер геологи, геодезийн зураглал, инженерийн тооцоо, өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг;	

“Барилга байгууламжийн зураг төслийн үе шат,
түүний бүрдэл” барилгын дүрэм боловсруулах
ажлын техникийн даалгавар

		Барилгын тухай хууль	ЗГ-108 Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм	
4	эх загвар зураг /эскиз/	<p>4.1.43 эх загвар зураг /эскиз/” гэж инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулсан барилга байгууламжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, тохижилт, гудамжны дэлгээсүүд, орчны барилгуудтай уялдсан байдал, эзлэхүүн төлөвлөлт, бүтээц, инженерийн хангамжийн ерөнхий шийдэл, эрүүл ахуй, галын аюулгүй байдал, нарны тусгал, барилгын давхрын байгуулалт, огтлол, нүүр тал /фасад/, архитектур, өнгөний шийдэл, үзүүлэлтийг тодорхойлсон баримт бичгийг</p> <p>23.2.Энэ хуулийн 23.1-д заасны дагуу баталгаажуулсан барилга байгууламжийн байршил, загвар зураг, техникийн нөхцөлүүдэд үндэслэн эх загвар зураг /эскиз/, иж бүрэн ажлын зураг төслийг боловсруулна.</p>	<p>4.2. Эх загвар зураг /эскиз/-т Барилгын тухай хуулийн 4.1.43-т тодорхойлсон асуудлыг тусган боловсруулах бөгөөд барилга байгууламжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зургийг М1:500, М1:1000, М1:2000, архитектур төлөвлөлт, технологи, барилга бүтээц, инженерийн хангамжийн байгуулалт, огтлолын зургийг М1:100, М1:150, М1:200, орчны тоймын зургийг М1:2000, М1:5000, М1:10000-ны масштабтайгаар тус тус гүйцэтгэнэ.</p>	
		Барилгын тухай хууль	ЗГ-108 Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм	Барилгын зураг. Техникийн төсөл ба ажлын зурагт тавих ерөнхий шаардлага MNS3757-3:2013
5	Загвар зураг	<p>4.1.27 барилга байгууламжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, орчны тойм, эзлэхүүн төлөвлөлт, барилгын нүүр тал /фасад/, өнгөний шийдэл, төлөвлөлтийг тодорхойлсон баримт бичгийг</p>	<p>3.6. Барилгын тухай хуулийн 4.1.27-д заасан загвар зургийг архитектур төлөвлөлтийн даалгавар болон зураг төслийн даалгаврыг үндэслэн боловсруулах бөгөөд аймаг,</p>	<p>Нэг маягийн бус эдэлхүүний ерөнхий байдлын загвар зураг. Бүтээцийн баримт бичиг боловсруулахад шаардлагатай, нэг маягийн бус эдэлхүүний үндсэн бүтцийг харуулсан, анхна өгөгдөл буюу даалгаврын хэмжээнд эдэлхүүний хялбаршуулсан дүрслэл,</p>

“Барилга байгууламжийн зураг төслийн үе шат,
түүний бүрдэл” барилгын дүрэм боловсруулах
ажлын техникийн даалгавар

			нийслэлийн ерөнхий архитектор батална.	үндсэн хэмжээ болон бусад өгөгдөл, техникийн шаардлагыг тусгасан баримт бичиг
		Барилгын зураг төслийн тогтолцоо. Ерөнхий журам MNS3757-1:2013		
6	Зураг төслийн бүтээгдэхүүн	Зураг төсөлд тавих бүх шаардлагын дагуу зураг төсөл зохиогч байгууллага, хувь хүний боловсруулан гаргасан төслийн (техникийн төслийн буюу эх загвар зургийн), ажлын зургийн, хайгуул судалгааны болон бусад техникийн баримт бичиг		
7	Төслийн баримт бичиг	Зургийн даалгавар, мөрдөж буй хууль тогтоомж, эрх зүйн акт, стандартын дагуу боловсруулсан гэдгийг үнэлж болохуйц, архитектур, үүрэг зориулалт-технологи, хийц бүтээц, инженер- техникийн шийдэл бүхий, цаашид ажлын зураг боловсруулахад хангалттай суурь болж чадах зургийн болон бичвэрийн цогц баримт бичиг (техникийн төсөл буюу эх загвар зураг)		
		Барилгын зураг төслийн тогтолцоо. Ерөнхий журам MNS3757-1:2013		Барилгын зураг. Техникийн төсөл ба ажлын зурагт тавих ерөнхий шаардлага MNS3757-3:2013
8	Төслийн баримт	Өөрөө бие даасан тэмдэглэгээ бүхий төслийн буюу ажлын баримт бичгийн бүрэлдэхүүн хэсэг. Тайлбар: Төслийн баримтад ажлын болон төслийн (техникийн төслийн буюу эх загвар зургийн) баримт бичгийг боловсруулахад шаардлагатай зургийн, биет эх загварын (макет, бичвэрийн, дуу дүрс бичлэгийн буюу хэд хэдэн мэдээллийн хэрэгсэл ашиглаж бүтээсэн, барилга байгууламжийн тухай шаардлагатай бүх мэдээллийг агуулсан баримтыг оруулж тооцно.		Төслийн буюу ажлын баримт бичгийн шифр: Зураг төслийн байгууллагын тухайн онд боловсруулсан баримт бичгийн бүртгэлийн дугаар.

		Барилгын зураг төслийн тогтолцоо. Ерөнхий журам MNS3757-1:2013	Барилгын зураг. Барилгын зураг төслийн баримт бичигт хийх хяналт MNS3757-2:2013	
9	Бичгэн баримт	Дан бичвэрээс бүрдэх буюу хүснэгтэлсэн бичвэрээс бүрдэх, бие даасан тэмдэглэгээ бүхий төслийн (техникийн буюу эх загвар зургийн) болон ажлын зургийн бичгэн хэсэг. 1-р тайлбар: Төслийн бичгэн баримтад тайлбар бичиг, объектийг тодорхойлсон буюу тайлбарласан төслийн хэсгүүдийн бичвэрийн хэсэг, материала, бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийн тодорхойлолтууд, техникийн нөхцлүүд, инженер хайгуулын дүгнэлтийн тайлан зэрэг техникийн баримт бичгийг хамруулна. 2-тайлбар: Төслийн бичгэн баримтад зургийн хуудсан дээр байгаа түүвэр, тодорхойлолт, тайлбар, хүснэгт, жагсаалт, ерөнхий заавар зэрэг бичвэрийн хэсгийг оруулахгүй.	Дан бичвэрээс бүрдэх буюу хүснэгтэлсэн бичвэрээс бүрдэх, бие даасан тэмдэглэгээ бүхий төслийн (техникийн буюу эх загвар зургийн) болон ажлын зургийн бичгэн хэсэг	
10	Зургийн баримт	Төрөл бүрийн дүрслэлийн аргаар техникийн болон бусад шийдлийг харуулсан, бие даасан тэмдэглэгээ бүхий төслийн (төслийн буюу эх загвар зургийн) болон ажлын баримт бичгийн зургийн хэсэг. Тайлбар: Зургийн хэсэгт зураг төсөл дээр төрөл бүрийн дүрслэлийн аргаар үзүүлсэн барилгын байгуулалт, огтлол, нүүр тал, зангилаа болон бүдүүвч, карт, электрон загвар, болон ажлын зургийн үндсэн бүрдэл хэсгүүдийг хамруулна.	Төрөл бүрийн дүрслэлийн аргаар техникийн болон бусад шийдлийг харуулсан, бие даасан тэмдэглэгээ бүхий төслийн (төслийн буюу эх загвар зургийн) болон ажлын баримт бичгийн зургийн хэсэг	
11	Төслийн цаасан баримт	Цаас буюу түүнтэй адилтгах зөөгүүр (кальк, бичил хальс, микрофиш) дээр гүйцэтгэсэн төслийн баримт буюу төслийн баримтын хэсэг.		
12	Төслийн цахим баримт	Бүтцийн тодорхой байдалтай өгөгдлүүдээс бүрдсэн, программ хангамжийн хэрэгслээр		

		бүтээгдсэн, шаардлагатай бол цахим гарын үсгээр баталгаажуулсан төслийн баримт бичиг.		
	ажлын баримт бичиг	Төслийн батладсан баримт бичгээр төлөвлөгдсөн барилгын объектийг барьж хэрэгжүүлэх буюу бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардагдах, барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэх, барилгын материал, бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангах техникийн шийдлийг тусгасан зургийн болон бичвэрийн цогц баримт бичиг. Тайлбар: Ажлын баримт бичигт ажлын зургийн үндсэн бүрдэл ба материал тоног төхөөрөмжийн тодорхойлолт, төсөв болон бусад нэмэлт материалууд багтана.		
		Барилгын зураг төслийн тогтолцоо. Ерөнхий журам MNS3757-1:2013	Барилгын зураг. Архитектурын ажлын зургийг гүйцэтгэх дүрэм MNS3757-11:2014	
13	ажлын зураг	Барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэх буюу хийц бүтээц, бүтээц, бүтээгдэхүүн, зангилааг үйлдвэрлэхэд шаардлагатай ажлын баримт бичгийн бүрэлдэхүүн хэсэг. Ажлын зураг нь зургийн болон бичвэрийн хэсгээс бүрдэнэ.	Барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэх буюу хийц бүтээц, бүтээц, бүтээгдэхүүн, зангилааг үйлдвэрлэхэд шаардлагатай ажлын баримт бичгийн бүрэлдэхүүн хэсэг. Ажлын зураг нь зургийн болон бичвэрийн хэсгээс бүрдэнэ.	
		Барилгын зураг. Барилгын зураг төслийн баримт бичигт хийх хяналт MNS3757-2:2013		
14	Зураг төслийн хяналт	Боловсруулж гаргасан төслийн буюу ажлын баримт бичгийг барилгын зургийн стандарт, норм ба дүрэм, бусад хууль тогтоомжид болон зургийн даалгаварт нийцэж буй эсэхийг нь шалгах хяналт.		
		Барилгын зураг. Техникийн төсөл ба ажлын зурагт тавих ерөнхий шаардлага MNS3757-3:2013		
15	Үндсэн бичлэг (булангийн хүснэгт)	3.1 Төслийн болон ажлын баримт бичгийн хуудсан дээр байршуулсан, тогтоосон хэлбэр хэмжээтэй хүснэгтэн доторхи зураг төслийн баримт бичгийн тухай цогц мэдээлэл		

16	Техникийн тодорхойлолт	Барилгын ажлыг гүйцэтгэх, бэотгэх, иж бүрдүүлэхэд зориулсан тоног төхөөрөмж, эдэлхүүн, материалын чанар, үйлдвэрлэлт, хадгалалт, баглаа боодол, тээвэрлэлт, барилгын угсралтын ажлын гүйцэтгэл, технологийн дараалалд тавигдах шаардлагыг тодорхойлсон зураг төслийн бичгэн баримт		
17	Ажлын тоо хэмжээ	Барилга барихад шаардагдах материал, эдэлхүүний тоо, хэмжээ, тээврийн зай, барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд шаардагдах ажиллах хүч, машин механизмын цагийг тооцоолж гаргасан хүснэгтэн баримт		
		Барилгын зураг. Ажлын зургийн ерөнхий өгөгдөл MNS3757-4:2013		
18	Барилгын ажлын зургийн ерөнхий өгөгдөл	3.1Ажлын зургийн нүүр хуудасны дараа ажлын зургийн ерөнхий өгөгдлийн хуудас байрлах ба ЗЕӨ гэсэн марктай байна. Уг хуудсанд дараах зүйлүүдийг тусгасан байна. Үүнд: Зургийн ерөнхий инженер /архитекторын тайлбар бичиг, ажлын зургийн үндсэн иж бүрдлүүдийн нэгдсэн жагсаалт /Хавсралтын 2-р хүснэгтийн дагуу/ байна. Жагсаалтад барилгын ажлын зургийн баримт бичгийн үндсэн иж бүрдлүүдийг дарааллаар нь бүрэн оруулна.		
19	Зургийн ерөнхий инженер архитекторын тайлбар бичиг	Ажлын зураг боловсруулах үндэслэл (газар олголтын шийдвэр, архитектур төлөвлөлтийн даалгавар, зургийн даалгавар, батлагдсан эх загвар зураг, захиалагчийн нэр, гэрээний дугаар); - Ажлын зургийг боловсруулахад баримталсан хууль эрх зүйн болон бусад норматив баримт бичгийн тухай товч тайлбар; - Объектын байршил, нэр, зориулалт, хүчин чадал;		

		<ul style="list-style-type: none"> - Байгаль цаг уурын нөхцөл, газар хөдлөлийн зэрэг, барилгын ангилал, эдэлгээний болон гал тэсвэрлэх зэрэг; - Цогцолборын барилгуудын бүрдэл, хот байгуулалтын шийдэл, техник-эдийн засгийн үндэслэл, тооцоо, зургийн бэлтгэл ажил, хийгдсэн судалгааны тухай товч тайлбар; - Зам, шугам сүлжээнд холбогдох байдал, инженерийн хангамжийн үндсэн шийдлийн тухай бичвэр; - Галын аюулгүй байдлын талаар тусгагдсан арга хэмжээ, галын аврах зам, гарц, шатны хангамж, тооцоо, галын машины явах зам, гал түймрээс барилгын бүтээцийг хамгаалах арга хэмжээ, гал унтраах, утаа зайлуулах систем, галын дохиолол болон зарлан мэдээлэх системийн талаар товч тайлбар; - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ; - Техник-эдийн засгийн нэгдсэн үзүүлэлтүүд; - Тус оюуны өмч нь ямар хүнд хамааралтай болох тухай тэмдэглэл(шаардлагатай тохиолдолд); - Төлөвлөж буй барилгад тавигдах ашиглалтын үеийн шаардлага (шаардлагатай тохиолдолд); 		
		Барилгын зураг. Техникийн төсөл ба ажлын зурагт тавих ерөнхий шаардлага MNS3757-3:2013		
20	Нэг маягийн бус эдэлхүүн(Хийц бүтээц, угсралтын блок):	Барилга угсралтын талбай дээр (угсралтын байгууллагын бэлтгэх цехэд) боловсруулагдаж бэлтгэгдсэн хийцийн, технологийн, эрчим хүчний, сантехникийн болон бусад системийн эдэлхүүн		
		Барилгын зураг. Техникийн төсөл ба ажлын зурагт тавих ерөнхий шаардлага MNS3757-3:2013	Барилгын зураг. Архитектурын ажлын зургийг гүйцэтгэх дүрэм MNS3757-11:2014	

“Барилга байгууламжийн зураг төслийн үе шат,
түүний бүрдэл” барилгын дүрэм боловсруулах
ажлын техникийн даалгавар

21	Барилгын бүтээц	Даацын болон хаших үүрэг бүхий хийцийн үндсэн элементүүдийн (суурь, хана, багана, дамнуруу, хучилт гэх мэт) систем	Барилгын бүтээцийн зураг: Даацын хаших болон гоо зүйн үүрэг бүхий хийцийн үндсэн элементүүдийн (суурь, хана, багана, дам нуруу, хучилт г.м) байршлын болон элементүүдийн зангилгааны зураглал.	
22	Барилгын эдлэхүүн		Барилга байгууламжийн бүтээцийн элемент болгон ашиглах зориулалттай (ихэвчлэн үйлдвэрт бэлтгэгддэг) бүтээгдэхүүн	
		Барилгын зураг. Техникийн төсөл ба ажлын зурагт тавих ерөнхий шаардлага MNS3757-3:2013	Барилгын зураг. Архитектурын ажлын зургийг гүйцэтгэх дүрэм MNS3757-11:2014	Барилгын зураг. Бетон, төмөр бетон бүтээцийн ажлын зураг MNS6495:2015
23	Барилгын бүтээцийн элемент	Угсармал болон цутгамал бүтээцийн бүрэлдэхүүн хэсэг	Угсармал болон цутгамал бүтээцийн бүрэлдэхүүн хэсэг	суурь, суурийн гулдмай, суурийн дамнуруу, багана, баганын холбоо, дамнуруу, татанга, хана,
24	Солбилцлын тэнхлэг	Барилга байгууламжийн модуль алхам болон давхрын өндрийн модулийг илэрхийлж буй солбилцлын шулуун		